



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 11536

Улаанбаатар хот

Захиалагчийн хяналт тавих тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

2. Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725022718

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
 04 дүүрт сарын 2025 ны өдрийн
 19:30 дугаар захирамжийн
 хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
 ЖАГСААЛТ

(сая төгрөг)

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	XIV.1.1.124	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, 31 дүгээр сургууль/	2022	2025	5,239.3	2,711.8
2	XIV.1.1.136	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 40 дүгээр хороо/	2022	2025	5,695.3	2,841.3
			ДҮН		10,934.6	5,553.1

ପାଦିବିରୁଦ୍ଧ କାହାରେ କାହାରୁ କାହାରିବା
କାହାରିବା କାହାରୁ କାହାରିବା

၁၀။ နှစ်မြောက်

(**ଦୁଇ ମାତ୍ରାକୁ**) - ୨୩ ହରି ହରି ହରିହରିହରି ॥

କୁଳ ପାଦାର୍ଥଙ୍କ ନିର୍ମାଣ କାର୍ଯ୍ୟ କରିବାକୁ ଅନୁରୋଧ କରିଛନ୍ତି ।

books is the best book

मात्रा

ପ୍ରକାଶନ ମିଟ୍ରି



፳፻፲፭